



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аялал жуулчлал, амралтын “Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2025/014/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2026 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас:70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа
Утас: 70350757 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЖДААН	Жижиг, дунд аж ахуй нэгж
СТОУС	Санхүүгийн тайлангийн Олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АЗДТГ	Аймгийн Засаг Даргын Тамгын Газар
ОНТ	Орон нутгийн төсөв
ЗГНХ,ЗДНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
ААЖИШЦ	Аялал жуулчлал, амралтын Их шүтээн цогцолбор



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.05 № 86
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ АМРАЛТЫН ИХ
ШҮТЭЭН ЦОГЦОЛБОРЫН
ЗАХИРАЛ Э.ОДХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн Аялал жуулчлал, амралтын Их шүтээн цогцолборын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд барилгын гадна 226.6 м² фасад ханыг сэргээж засварлах ажлын зураг төсвийг хийлгэсэн байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Засаг даргын 2025 оны 03 сарын 31-ний өдрийн А/260 дугаар захирамжаар 370,795.2 мянган төгрөгийн барилга, байгууламж, үндсэн хөрөнгийг хүлээн авч, бүртгэл тайланд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 2 түрээслэгч байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж, нийт 13,300.0 мянган төгрөгийн түрээсийн орлогыг Эрдэнэт санд төвлөрүүлэн ажиллажээ.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах

012505473

үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	93,906,498.46	92,092,746.24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,500,722.46	5,002,970.24
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,500,722.46	5,002,970.24
31210	Төгрөг	7,500,722.46	5,002,970.24
31213	Арилжааны банк дахь харилцах	7,500,722.46	5,002,970.24
33	АВЛАГА	16,327,886.00	16,327,886.00
33500	Бусад авлага	16,327,886.00	16,327,886.00
33510	Байгууллагаас авах авлага	16,327,886.00	16,327,886.00
35	БАРАА МАТЕРИАЛ	70,077,890.00	70,761,890.00
35100	Түүхий эд материал	68,325,790.00	68,910,790.00
35110	Тусгай зориулалттай материал	68,325,790.00	68,910,790.00
35400	Хангамжийн материал	1,752,100.00	1,851,100.00
35410	Бичиг хэргийн материал	90,000.00	0.00
35420	Аж ахуйн материал	1,662,100.00	1,851,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,865,099,500.38	3,716,363,355.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,865,099,500.38	3,716,363,355.39
39200	Биет хөрөнгө	3,864,746,375.49	3,716,322,730.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,740,821,179.00	3,740,821,179.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-660,009,956.12	-725,029,720.40
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	46,991,899.08	46,991,899.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,050,164.02	-23,158,669.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,179,267.92	48,179,267.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,690,498.45	-15,717,873.89
39214	Бусад үндсэн хөрөнгө	995,153,968.75	995,153,968.75
39215	Хуримтлагдсан элэгдэл	-276,649,320.67	-350,917,320.70
39300	Биет бус хөрөнгө	353,124.89	40,624.85
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-896,875.11	-1,209,375.15
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,959,005,998.84	3,808,456,101.63
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,959,005,998.84	3,808,456,101.63
51	Засгийн газрын хувь оролцоо	3,959,005,998.84	3,808,456,101.63
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	4,982,143,581.60	4,982,143,581.60
51200	Хуримтлагдсан үр дүн	-1,023,137,582.76	-1,173,687,479.97
51210	Өмнөх үеийн үр дүн	-841,357,023.21	-1,023,137,582.76
51220	Тайлант үеийн үр дүн	-181,780,559.55	-150,549,897.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,959,005,998.84	3,808,456,101.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	81,071,661.52	479,276,110.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,071,661.52	479,276,110.72
120	Нийтлэг татварын бус орлого	81,071,661.52	479,276,110.72
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	81,071,661.52	108,480,875.72
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	370,795,235.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	262,852,221.07	404,937,483.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,852,221.07	404,937,483.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	262,852,221.07	404,937,483.83
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,386,035.17	110,294,627.94
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	74,402,853.38	105,091,177.94
210813	Бусад зардал /ТӨҮГ/	16,983,181.79	5,203,450.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	171,466,185.90	294,642,855.89
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	171,466,185.90	294,642,855.89
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-181,780,559.55	74,338,626.89
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	224,888,524.10
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	224,888,524.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-181,780,559.55	-150,549,897.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	81,071,661.52	108,480,875.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,071,661.52	108,480,875.72
120	Нийтлэг татварын бус орлого	81,071,661.52	108,480,875.72
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	81,071,661.52	108,480,875.72
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,956,035.17	110,978,627.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,956,035.17	110,978,627.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	91,956,035.17	110,978,627.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,402,853.38	80,462,467.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	74,402,853.38	80,462,467.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,553,181.79	30,516,160.94
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	17,553,181.79	30,516,160.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-10,884,373.65	-2,497,752.22
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-10,884,373.65	-2,497,752.22
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,385,096.11	7,500,722.46
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,500,722.46	5,002,970.24

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,886,338,601.60	-841,357,023.21	4,044,981,578.39
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,886,338,601.60	-841,357,023.21	4,044,981,578.39
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	95,804,980.00	0	95,804,980.00
9	Тайлант үеийн үр дүн	0	-181,780,559.55	-181,780,559.55
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,982,143,581.60	-1,023,137,582.76	3,959,005,998.84
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,982,143,581.60	-1,023,137,582.76	3,959,005,998.84
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,982,143,581.60	-1,023,137,582.76	3,959,005,998.84
19	Тайлант үеийн үр дүн	0	-150,549,897.21	-150,549,897.21
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	4,982,143,581.60	-1,173,687,479.97	3,808,456,101.63

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

2025 оны санхүүгийн тайланг залруулаагүй.

Аудитаар нийт 176.0 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс, 176.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд 176.0 мянган төгрөгийн цалинг илүү олгосон зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчилд албан шаардлага хүргүүлж байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зорилтот түвшний хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд хянах, удирдах боломжтой цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг нийт 5,681.3 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан зардлын төсөвт багтааж ажиллах.

2. Түрээсийн орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орхон аймгийн засаг даргатай гэрээ байгуулж түрээсийн орлогын 13,300.0 мянган төгрөгийн 60 хувийг Орон нутгийн өмчийн дансанд төвлөрүүлэлгүй Эрдэнэт санд 100 хувь төвлөрүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", аймгийн ИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 02/18 тоот тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын 3 дугаар хавсралтын 3.2-т "Орон нутгийн өмчийн газар нь тухайн жилд түрээсээр ашиглуулах эд хөрөнгийн жагсаалт, түрээсийн төлбөрийн хэмжээг гаргаж аймгийн Засаг даргаар батлуулна", 3.3-т "шууд түрээсийн орлогыг 100 хувь, дам түрээсийн орлогын 60 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дам түрээсийн орлогын 60 хувийг Орон нутгийн өмчийн газарт төвлөрүүлж байх.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 176.0 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.	1	176.0	1	176.0								
Тайлант онд хянах, удирдах боломжтой үндсэн, нэмэгдэл цалин хөлс ба нийгмийн даатгалын шимтгэлийн зардал зэргийг нийт 5,681.3 мянган төгрөгөөр хэтрүүлж ажилласан байна.	1	0					1	0				
Орхон аймгийн Засаг даргатай дөрвөлсөн гэрээ байгуулж түрээсийн орлогын 13,300.0 мянган төгрөгийн 60 хувийг Орон нутгийн өмчийн дансанд төвлөрүүлэлгүй Эрдэнэт санд 100 хувь төвлөрүүлсэн байна.	1	0					1	0				
Дүн	3	176.0	1	176.0			2	0.0				

